

ХАМГААЛАЛТАЙ Ч ХАЙХРАМЖГҮЙ ТӨГРӨГ

Хүн бүрийн гар дамжин эргэлддэг атлаа хэн ч сайн таньдаггүй нэгэн нууцлаг найз бол Монгол төгрөг. Зээл нэхэхэд нэрийддэг, цалин ирэхэд хүсэн хүлээдэг, тасалбар авахад барьж гүйдэг, харин хуурамч байвал хэрэг төвөгт чирдэг нэгэн “танилгүй танил”. Төгрөг бол зүгээр л төлбөрийн хэрэгсэл бус, бидний түүхийн баталгаа, тусгаар тогтнолын бичмэл бэлгэдэл. Гэвч өнөө цагийн хүмүүс, тэр дундаа миний үеийнхэн төгрөгтэй “хайргүй найзууд” болж хувирсан мэт. Гарт нь орж ирмэгц гарч оддог, хэн нэгэн өгвөл хуурамч уу жинхэнэ үү гэж бодолгүй хүлээж авдаг. Төгрөгийг нүдээрээ биш, зөвхөн хэрэгцээгээрээ “хардаг” болсон энэ хандлага нь нийгмийн нэгэн гүн асуудлын илэрхийлэл юм.

Төгрөгийг зөв хэрэглэж сурах нь зөвхөн эдийн засгийн ухаан бус, ёс суртахууны асуудал ч мөн юм. Нэгэн цагт “түрийвчгүй бол тэрсэлдэж чаддаггүй” хэмээх егөөтэй үг байсан бол өнөөдөр “интернэт банкгүй бол хүн биш” гэх хандлага газар авчээ. Мөнгөтэй зөв харьцах ухааныг зөвхөн хэтэвчтэй холбож ойлгох нь өрөөсгөл. Энэ бол хүний ухамсар, амьдралын хэв маяг, үнэт зүйлсийн тусгал юм. Төгрөгийг хайрлана гэдэг нь дэвсгэртийг цэвэрхэн авч явах, тооцоогоо зөв хийх зэрэг жижиг үйлдлүүдээс эхэлдэг. Гэтэл өнөөдөр бид мөнгийг “байх ёстой зүйл”, “гадаад үзэмж” мэт хүлээж авдаг болжээ. Цалин буух өдөр баярладаг ч, хагас сарын дараа “хаачив аа” гэж толгойгоо гашилгах хүмүүс олон. Энэ нь санхүүгийн боловсролгүй байдал, хэрэглээний зохисгүй хандлагын үр дагавар юм. Бид мөнгөн тэмдэгтээ харж хүндлэхийн оронд, хэрэглэж дуусмагцаа мартах хэв маяг их болсон. Төгрөгийн ард байгаа соёл, түүх, шинжлэх ухаан, зохион бүтээлтийн үнэ цэнийг ухаарах ухамсар нь өөрийгөө болон нийгмээ ойлгох мэдрэмжийн илэрхийлэл болж чадна. Бидний амьдралын бүхий л хэсэг мөнгөтэй салшгүй холбоотой. Гэвч энэ холбоо хэрхэн үүсэж, ямар үр дагаварт хүргэдгийг тун цөөн хүн эргэцүүлдэг. Төсөв зохиох, хуримтлал үүсгэх, төлбөр тооцоогоо хариуцлагатай хийх зэрэг үйлдэл нь зөвхөн “насанд хүрэгчдийн ажил” биш. Хүүхэд байх цагаасаа эдгээр хандлагыг суулгах нь санхүүгийн боловсролын үндэс болдог. Гэтэл өнөөдөр санхүүгийн сахилга бат, хариуцлага, төлөвлөлтийн талаар албан ёсоор заадаг, тогтмол хөтөлбөр хэрэгжүүлдэг сургуулийн тоо тун цөөн. Мөн хичээлийн хөтөлбөрт багтсан ч онолын хүрээнд хэлэлцээд өнгөрөх нь элбэг. Харин практикт суурилсан, өдөр тутмын амьдралтай уялдсан заавар, дадал бий болгох нь дутагдаж байна.

Монголын үндэсний мөнгөн тэмдэгтийн анхны эх үүсвэр, түүхэн хөгжлийг мэддэг хүн цөөн. Зарим нь “Сүхбаатарын зурагтай ногоон дэвсгэрт” гэхээс

хэтрэхгүй. Тиймээс төгрөгийн хамгаалалтын элементүүдийн тухай ярихад чихээ таглаж, “надад хамаагүй, зүгээр л үйлчлүүлчихье” гэж хүлээж авдаг. Гэтэл тэрхүү хамгаалалтын зурвас, усан хээ, хэт ягаан туяанд тодордог нууц тэмдэглэгээнүүд нь зүгээр ч нэг дизайн биш. Түүх, шинжлэх ухаан, оюуны өмчийн нэгдэл юм. Тиймээс төгрөг бол соёлын үнэт өв, ухаалаг зохион бүтээлийн жишээ юм. Гэсэн ч энэ гайхамшигийг анзаарахгүй хүмүүсийн шалтгаан нь зөвхөн хайхрамжгүй байдал биш. Энэ нь мөнгөний талаарх боловсрол хомс, санхүүгийн сахилга батгүй байдлын шууд үр дагавар билээ. Сургуульд бид Пифагорын теоремыг цээжилдэг хэр нь хуурамч мөнгийг хэрхэн ялгах талаар хэн ч зааж өгдөггүй. Тиймдээ ч 20,000 төгрөгийн дэвсгэртийн өнгө арай ондоо байхад ч "яха вэ дээ" гээд халаасалдаг.

Төгрөгийн түүх нь Монгол Улсын тусгаар тогтнол, эдийн засгийн бие даасан байдлын салшгүй хэсэг юм. Гэтэл төгрөгийн өнөөдрийн дүр төрх нь хэтэвчний ёроолд

мартагдсан дугуй цаас мэт хандах нэгэн хэсэг, харин цахим банкны хэрэглээний дэвтэр мэт хөнгөн хандах өөр нэг хэсгийн хандлагаар хоёр туйлд хуваагдаад байна. Хүмүүс мөнгө “иддэг”, “саадаг”, “цацдаг”, харин хамгаалдаггүй. Тийм болохоор ч "мөнгө хүнийг эвддэг" гэдэг өгүүлбэр элбэг. Нэгэн жишээ дурдъя: манай ангийн нэг охин өдөрт 5 удаа “посс”-оор ундаа авч уудаг хэр нь 100₮-ийн хураамжийг “данс хоосон байна” гээд төлж чаддаггүй.

Хүүхдэд багаас нь мөнгөтэй хэрхэн зөв харьцахыг заах нь маш чухал. Ар гэртээ аав, ээж маань бидэнд “бэлэн мөнгөтэй болгоомжтой байгаарай” гэж хэлдэг ч түүнийгээ яаж хийхийг тайлбарладаггүй. “Бэлэн мөнгөөр биш, карт уншуулаад сур” гэж зөвлөдөг ч, хэн нэгний АТМ дээр мартагдсан картаар шууд гүйлгээ хийвэл яах вэ гэдгийг заадаггүй. Гэтэл хүүхэд бол дуурайгч амьтан. Тэр ч байтугай багш нар маань “Та нар санхүүгийн сахилга баттай бай” гээд халаасандаа зоосгүй яваа нь ч бий. Иймд эцэг эх, асран хамгаалагчид, багш сурган хүмүүжүүлэгч нар төгрөгтэй харьцах мэдлэгийг анхан шатнаас нь зааж, хэлж, үзүүлж байх хэрэгтэй байна. 1000 төгрөгийг 2 хувааж, 500-аар нь юу хийж болохыг хүүхдэд ойлгуулж, үлдсэн 500-г хадгалах ухаан заах нь эдийн засгийн боловсролын эхлэл юм.

Банкны дэвсгэртийн хамгаалалтын элемент бол бидний тусгаар тогтнолын бичмэл баталгаа. Хуурамч мөнгө эргэлдэж буй нийгэмд энэ хамгаалалт бол зөвхөн нууц тэмдэг биш, харин ард иргэдийн хандлага, боловсролын чухал хэмжүүр. Төгрөгийг хайрлах гэдэг нь зөвхөн тоо хөөцөлдөх биш, харин эх орон,

үнэ цэнэ, итгэлцлийг хамгаалах гэсэн үг. Өнөөдөр бид хамгаалалтын шугамыг мэддэггүй учраас хуурамч дэвсгэртээр гүйлгээ хийж, маргаашийнхаа итгэлийг алдаж байна.

18 нас хүрч, насанд хүрэгчдийн ертөнцөд хөл тавьж буй миний хувьд төгрөг бол зүгээр нэг эдийн засгийн хэрэгсэл биш, харин ирээдүйн сонголтыг тодорхойлогч гүүр юм. Монгол төгрөг 100 нас хүрч буй энэ үед бид зөвхөн өнгөрсөн түүхийг биш, мөнгөтэй харьцах өнөөгийн зан төлөв, ирээдүйн хандлагыг ч гэсэн шинжлэн дүгнэх хэрэгтэй. Яагаад гэвэл бид хамгаалагчгүй төгрөгийг биш, хамгаалалттай ч хайхрамжгүй ард түмнийг бий болгож байгаагаа ухамсарлах цаг ирсэн. Монгол төгрөг- гялгар дэвсгэрт, гэгээн бахархал. Харин түүнийг ойлгоогүй нийгэм- гэнэн хэрэглэгч, гаж хандлагын үр дүн. Бидэнд мөнгөн дэвсгэртээ биш, мөнгөтэй харьцах хандлагаа хамгаалах ухаан дутагдаж байна. Энэ бол зөвхөн банк, төрийн хариуцлага бус, эцэг эх, багш, хувь хүний ухамсрын асуудал юм.

Дүгнэж хэлэхэд, төгрөг бол Монголын тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг төдийгүй, монгол хүний оюун ухаан, соёлын өвийн нэгэн салшгүй хэсэг билээ. Бид төгрөгөө хамгаална гэдэг нь зүгээр л хуурамч дэвсгэртээс сэргийлэх тухай биш, харин оюуны өмч, түүхэн бахархал, ирээдүйн төлөвшилд анхаарал тавих тухай асуудал юм. Мөнгөний зөв хэрэглээг сурч, хандлагаа өөрчилснөөр бид зөвхөн эдийн засгаа бус, нийт нийгмээ ч гэсэн шинэ шатанд хүргэж чадна. Тиймээс төгрөгийн 100 жилийн ойг өнгөрсөн түүхийг биш, ирээдүйн хандлагыг шинээр эхлүүлэх боломж гэж харцгаая.

Нийслэлийн Ерөнхий Боловсролын 5 дугаар сургуулийн

12в ангийн сурагч Н.Номин-Эрдэнэ